

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.10 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Нэг иргэн-Нэг бүртгэл" үндэсний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд /Ц.Нямдорж/-д даалгасугай.
- 3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн төсөл, гадаад зээл, тусламжийн бодлогод тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Хууль зүй, дотоод хэргийн сайд /Ц.Нямдорж/ нарт үүрэг болгосугай.
- 4.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд /Ц.Нямдорж/-д даалгасугай.
- 5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

## **”НЭГ ИРГЭН-НЭГ БҮРТГЭЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.2.8-д “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.”, 5.2.9-д “Улсын бүртгэлийн архивыг бүхэлд нь цахимжуулна”, 5.2.10-т “**“Нэг иргэн-Нэг бүртгэл”** хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн болон цахим бизнес, онлайн банкны үйлчилгээг жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлнэ.”, 5.4.13-т “Хууль зүйн салбарын байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.” гэсэн зорилтуудыг тус тус хэрэгжүүлэхээр тусгасан.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалт”-д “Нэг иргэн-Нэг бүртгэл” үндэсний хөтөлбөрийг шинээр боловсруулахаар тусгасан.

Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025 онд)”-д хаягжилтын системийн уялдааг сайжруулж нэгдмэл болгоно, цахим засгийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, хатуу болон зөөлөн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлоготой хөгжүүлж, төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож хөгжүүлэхээр тусгасан.

“Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах тухай” Улсын Их Хурлын 2009 оны 100 дугаар тогтоол, Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн дагуу бүртгэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулсны үр дүнд манай улс биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлээр баталгаажсан иргэний улсын бүртгэлийн онлайн систем, эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн онлайн систем, цахим архивын сантай болж, иргэд улсын бүртгэлийн лавлагааг Төрийн үйлчилгээний цахим машинаас авах боломжтой болсон зэрэг үр дүнд хүрсэн.

Гэвч төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох байдал хязгаарлагдмал, нэг иргэний мэдээллийг олон талд давхардалтай, зөрүүтэй гаргадаг, улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд бүртгэлийн нэгжүүд буюу 67 хороо, 303 сум холбогдоогүй, улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагуудын мэдээллийн санд хандан авах боломжгүй байдаг, цахим бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлээгүйгээс шалтгаалж, иргэд олон төрлийн баримт бичиг бүрдүүлэх, хүлээх, цаг хугацаа алдах зэргээр төрөөс шуурхай, чанартай үйлчилгээг авч чадахгүй байна.

Улсын бүртгэл нь иргэнд суурилсан төрийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний эрхийг хангах, төрийн ой санамжийг бүрдүүлэх, бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай болгоход чухал нөлөөтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ын 2.1.2, 2.1.3-т “төрийн цахим мэдээллийн сан” гэж захиргааны байгууллагын суурь болон төрөлжсөн цахим мэдээллийн санг; “суурь цахим мэдээллийн сан” гэж иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хаягийн бүртгэл, газрын кадастрын мэдээллийн санг” тус тус ойлгохоор заасан.

Иймд иргэнд суурилсан бүртгэлийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулах, улмаар уг суурь мэдээллийг бусад байгууллагатай солилцох боломжийг хангах, нэг эх сурвалжаар суурь мэдээллийн санг бүрдүүлж, төрийн байгууллага хоорондын мэдээллийг зөрүүг арилгах, улсын бүртгэлийн байгууллагын салбар, нэгжийг бүртгэлийн нэгдсэн онлайн сүлжээнд холбож орон зайнаас хамааралтай үйлчилгээний хүртээмжгүй байдлыг арилгах шаардлагатай байна.

Улсын бүртгэлийн байгууллага нь иргэний 19, эд хөрөнгийн 29, хуулийн этгээдийн бүртгэлийн 10, зохиогчийн эрхийн 3, аж үйлдвэрийн өмчийн эрхийн 33, архивын 28, нийт 122 төрлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үзүүлдэг.

Улсын бүртгэлийн байгууллагын гаргасан тоон мэдээллээр иргэн, хуулийн этгээдэд 2016 онд нийт 438 мянга гаруй лавлагааг олгосон байх бөгөөд энэ нь иргэдэд төдийгүй бүртгэлийн байгууллагад ажлын ачаалал, зардал нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болдог тул улсын бүртгэлийн архивын баримтыг бүрэн цахимжуулж, цахим хэлбэрээр олгох мэдээлэл, лавлагааны үйлчилгээг өргөжүүлэх замаар иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэйгээр үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Мөн улсын бүртгэлийн архивын эх нотлох баримт бүрэн цахимжаагүй, цахимжсан зарим төрлийн баримтад нэмэлт, баяжилтыг хийх, баримтыг хэрэглээнд ашиглах боломжгүй байгаа тул цаашид цахимжуулалтыг үргэлжлүүлэн

хийх, хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг бий болгож, улсын бүртгэлийг цахимаар хөтлөх боломж бүрдүүлнэ.

Түүнчлэн улсын бүртгэлийн мэдээллийн цахим сангийн тоног төхөөрөмж, програм хангамж болон цаасан суурьт баримт хадгалах байр, өрөөг засварлах, сайжруулах, шинэчлэх ажил хийгдэхгүй, хөрөнгө оруулалт дутагдалтай явж ирснээс улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаанд дараах доголдол гарч, эрсдэл үүсч энэ нь иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд сөргөөр нөлөөлдөг.

Тухайлбал, үйл ажиллагаандаа өгөгдөл хадгалах зориулалт бүхий нийт 67 сервер, 8 хадгалах төхөөрөмж, 4531 ширхэг компьютер, дагалдах тоног төхөөрөмж ашиглаж байгаагаас 48 сервер /71.6 хувь/, 8 хадгалах төхөөрөмж болон компьютер, дагалдах тоног төхөөрөмжийн 85 хувь нь ашиглалтын хугацаа хэтэрсэн нь бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах боломжгүй нөхцөл үүсч, тоног төхөөрөмж, технологиос шалтгаалсан саатал удаа дараа гардаг.

Мөн олон улсын зээл тусламжийн хүрээнд хийгдсэн зарим програм хангамжийн эх кодыг гүйцэтгэгч талаас хүлээлгэн өгөөгүйгээс програм хангамжийн хөгжүүлэлт, сайжруулалт хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй байна.

Мэдээллийн сангийн удирдлагын системүүдийн лицензийн хугацаа дууссан, лицензгүйгээр ашиглаж байгаа нь мэдээллийн санд гэмтэл саатал гарах үед мэргэжлийн байгууллагаас тусламж авах, цаашид шинэчлэгдсэн хувилбарыг ашиглах боломжгүй нөхцөлд байна. Мэдээллийн сангуудыг нөөцлөх тоног төхөөрөмжийн багтаамж дүүрсэн, өмнө нөөцөлсөн мэдээллийг устгаж шинээр нөөцлөх байдлаар нөөцлөлтийг 7 хоногоор хийж байгаа нь мэдээллийн сангийн аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллах нөхцөлийг хангаж чадахгүй байна.

Улсын хэмжээнд бүртгэлийн архив 33 нэгжид байршиж байгаа бөгөөд тэдгээрээс 8 аймаг, 1 дүүрэг архивын зориулалтын өрөөтэй, бусад архивууд зориулалтын бус байртай, архивын байрны хүрэлцээгүйгээс төв архив болон зарим аймаг, дүүргийн архивын материал хонгилын давхар, автомашины гражид байгаа нь архивын баримт хадгалах орчны стандарт шаардлагыг хангаж чадахгүй, улсын бүртгэлийн эх нотлох баримт бүхий архив үрэгдэх, устах өндөр эрсдэлтэй байна. Архивын байрны багтаамж, хүрэлцээ нь өнөөгийн шаардлагыг хангахгүй, зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, баримт бичиг шилжүүлэх, тээвэрлэхэд аюулгүй байдал алдагдсанаас устах, гэмтэх эрсдэлтэй.

Иймд улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан, цахим сүлжээний нууцлал, аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангах тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах, шинээр худалдан авах, нөөц бий болгох, архивын баримтыг зориулалтын өрөө, тасалгаанд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг цогцоор нь үе шаттайгаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улс иргэний үнэмлэхийн бэлдэц, иргэдийн гадаадад зорчих баримт бичиг үндэсний гадаад паспортын бэлдэцийг технологи өндөр хөгжсөн гадны улсуудад үйлдвэрлүүлж бичилтийг нь хувийн компаниар хийлгэж байна. Энэ байдал нь Монгол Улсын иргэдийн үндсэн баримт бичиг иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын нууцлал аюулгүй байдал алдагдах мөн гадны улсуудаар захиалга өгч бэлдэц үйлдвэрлүүлэх, хувийн компаниар бичилт хийлгэх, тээвэр, гаалийн татвар зэрэгт их хэмжээний хөрөнгө урсаж байна. Иргэдийнхээ хувийн эрх зүйн баримт бичиг, нууцлал, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахад анхаарч иргэний үнэмлэхийн бэлдэц, бичилт болон гадаад паспортын бичилтийг улсын бүртгэлийн байгууллагын хэвлэх үйлдвэрт хийхээр хөтөлбөрийн нэг зорилт болгон тусгалаа.

Засаг захиргааны нэгжид суурилсан хаягжилтын өнөөгийн байдал нь нэгдсэн стандарт, системгүй, ойлгомжгүй байгаа нь орчин үеийн бизнесийн болон төрийн үйлчилгээний шаардлагыг хангахгүй байгаа тул газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгож, бүртгэлийн үйлчилгээнд ашиглах зайлшгүй шаардлага тулгардаг.

Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, цахим сүлжээний хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан төрийн үйлчилгээ, лавлагааг орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, иргэний үнэмлэхийн бичил санах ойд тоон гарын үсгийг суурилуулах, ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх, түүнийг ашиглан хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хийхэд ашиглах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас үйлчилгээ авах боломжтой болгох, Монгол Улсад хаягийн нэг стандарт, нэгдсэн санг бий болгох, иргэний хаягийн шинэчилсэн бүртгэлийг явуулах, төрийн ой санамжийг бий болгох, түүнд суурилсан бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэг зайлшгүй шаардлагад тулгуурлан “Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийг боловсруулав.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

2.1. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлэх, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, үндэсний аюулгүй байдлыг ханган төрийн ой санамжийг бэхжүүлж, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэн цахим хэрэглээг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

**Зорилт 1.** Бүртгэлийн байгууллагын системийн хэмжээнд ашиглагдаж байгаа техник ба програм хангамж, мэдээллийн санг сайжруулах;

**Зорилт 2.** Архивын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг стандартад нийцүүлэн боловсронгуй болгож, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулах;

**Зорилт 3.** Дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний баримт бичиг үйлдвэрлэх хэвлэх үйлдвэрийг өргөтгөх;

**Зорилт 4.** Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгө, оюуны өмчийн мэдээллийн санг чанаржуулах, нэгдсэн удирдлага бүхий систем бий болгох;

**Зорилт 5.** Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгох;

**Зорилт 6.** Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, шинэ дэвшилтэт технологийн шаардлагад нийцүүлэн хүний нөөцийг чадавхжуулах;

**Зорилт 7.** Тоон гарын үсэг, иргэний үнэмлэхийн хэрэглээг нэмэгдүүлж, иргэний үнэмлэхийн бичил санах ойд цахим өгөгдлийг суурилуулах,

**Зорилт 8.** Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт оруулж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх;

**Зорилт 9.** Иргэн, төрийн болон төрийн бус байгууллагуудтай мэдээлэл солилцох.

### 2.3.Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлнэ.

## Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

### 3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Иргэний бүртгэлийн програм хангамжийг шинэчлэн сайжруулах;

3.1.2. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн програм хангамжийг шинэчлэн сайжруулах;

3.1.3. Хуулийн этгээдийн бүртгэлийн програм хангамж боловсруулах;

3.1.4. Оюуны өмчийн програм хангамжийг шинэчлэн боловсруулах;

3.1.5. Архивын нэгдсэн програм хангамжийг боловсруулах;

3.1.6.Мэдээллийн сангийн нөөцлөлтийг автомат горимоор хийх програм хангамж боловсруулах;

3.1.7. Цахимжуулсан мэдээллийг бүртгэлд ашиглах програм боловсруулах;

3.1.8. Бүх мэдээллийн сангуудыг хянадаг програм хангамжтай болох;

3.1.9. Бүртгэлийн тайлангийн програм, иргэний үнэмлэхийн мэдээлэл шалгах програмыг боловсруулж, нэвтрүүлэх;

3.1.10. Бүртгэлийн системд ашиглагдаж байгаа сервер, компьютер, тоног төхөөрөмжийн 80-аас доошгүй хувийг шинэчилэн, нөөцийг бүрдүүлэх;

3.1.11. Сүлжээний нууцлал аюулгүй байдлыг ханган, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

3.1.12. Бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй Нийслэлийн 67 хороо, хүн ам ихээр төвлөрсөн 50 сумыг шат дараалалтайгаар улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох;

3.1.13. Цахилгааны тасалдлаас урьдчилан сэргийлэх 2 талын тэжээлийн үүсгүүр, нэгдсэн сүлжээ, сервер, үйлчилгээний байруудыг хангах хүчин чадал бүхий цахилгааны нөөц эх үүсвэртэй болох.

### **3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.2.1. Архивын байранд тавигдах шаардлагад нийцсэн зориулалтын байрны зураг төслийг гаргаж, бариулах, зарим бүртгэлийн нэгжийн архивын орчин нөхцөлийг сайжруулж, засвар үйлчилгээ хийх;

3.2.2. Архивын эх нотлох баримтыг цахимжуулахад шаардагдах програм хангамж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.3. Иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын эх нотлох баримтыг бүрэн цахимжуулан дуусгах.

### **3.3.Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.3.1.Монгол Улсын иргэний үнэмлэхийн нууцлал бүхий бэлдэц, бичилтийг хийх, үндэсний энгийн цахим гадаад паспортад бичилт хийх хүчин чадалтай улсын тусгай үйлдвэрийг байгуулж ажиллуулах;

3.3.2.Иргэний үнэмлэхийн бэлдэцийг бэлтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авах;

3.3.3.Иргэний иргэний үнэмлэхийн хэвлэх үйлдвэрийн байрыг өргөтгөх бэлтгэл ажлыг хангаж, бариулах;

3.3.4.Олон улсын стандартын шаардлагад нийцсэн үндэсний энгийн цахим гадаад паспорт хэвлэх машиныг хэрэглээнд нэвтрүүлэх;

3.3.5.Үндэсний энгийн гадаад паспортын мэдээллийг хүлээн авах, дамжуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч, төв, орон нутгийн нэгжүүдийг хангах;

3.3.6 Бүртгэлийн иргэдэд үйлчлэх байруудын нөхцөлийг орчин үеийн үйлчилгээний стандартад нийцүүлэн сайжруулах.

### **3.4.Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.4.1. Олон улсын технологийн чиг хандлагад нийцүүлж бүртгэлийн чиглэл тус бүрээр зааглагдсан олон салангид байгаа мэдээллийн сангуудыг нэгдсэн мэдээллийн хайлтын санг хөгжүүлэн тайлангийн системийг боловсруулах, нэг удирдлагатай системд оруулах;

3.4.2. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх, улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн чанарыг сайжруулах;

3.4.3 Засаг захиргааны нэгжийн кодчиллол болон нэршлийн мэдээллийн сан дахь зөрүүтэй байдлыг арилгаж, нэгдсэн стандартад оруулах.

### **3.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.5.1. Төрийн байгууллагуудтай хамтран хаягийн шинэчилсэн бүртгэлийн мэдээллийн санг бий болгох ажлыг зохион байгуулах;

3.5.2. Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгох;

3.5.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн систем дэх газрын нэгж талбарын дугаарыг газрын кадастрын суурь мэдээллийн сантай холбож, уялдуулах;

3.5.4. Газар зүйн мэдээллийн санд суурилсан хаягийн нэгдсэн санд үндэслэн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн шинэчилсэн хаягийг бүртгэх;

3.5.5. Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэний оршин суугаа хаягийг иргэний үнэмлэхийн бичил санах ойд бичих ажлыг зохион байгуулах.

### **3.6. Хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.6.1. Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг сургах, шинэ дэвшилтэт технологийн шаардлагад нийцүүлэн мэдлэг, ур чадварыг сайжруулах, давтан сургах, чадавхжуулах;

3.6.2. Бүртгэлийн төв, орон нутгийн нэгжийг мэргэшсэн, ур чадвар бүхий боловсон хүчнээр хангах;

3.6.3. Мэдээллийн технологийн чиглэлийн албан хаагчдыг мэргэшүүлэх, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бий болгох.

### **3.7. Хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.7.1. Тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн бичил санах ойд суурилуулж олгох тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас авах;

3.7.2. Шинээр хэвлэгдэх иргэний үнэмлэхийн бичил санах ойд тоон гарын үсгийн түлхүүрийн хослолыг үүсгэх, чипийн файлын бүтэц, карт хэвлэх системийн болон PKI идэвхжүүлэх програм хангамжийг боловсруулах;

3.7.3. Иргэдэд олгогдсон иргэний үнэмлэхийн PKI апплетыг шинэчилж, 2048 бит түлхүүрийн хослолыг бичих боломжтойгоор програм хангамжийг боловсруулах;

3.7.4. Иргэний үнэмлэхийн бичил санах ойд тусгагдсан тоон гарын үсгийн мэдээллийг таних програм боловсруулах;

3.7.5. Бүртгэлийн анхан шатны нэгжээр дамжуулан иргэдэд тоон гарын үсгийг олгох ажлыг эхлүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх.

### **3.8. Хөтөлбөрийн 8 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.8.1. Төрийн үйлчилгээний цахим системд бүртгэлийн 60 үйлчилгээг холбож, цахим хэлбэрт шилжүүлэх;

3.8.2. Улсын бүртгэлийн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, оюуны өмчийн боломжит үйлчилгээг цахим хэлбэрээр хөтлөн явуулах системийг боловсруулах;



3.8.3.Хөдөлгөөнт холбооны технологид суурилсан бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлж, хөгжүүлэх;

3.8.4.Бүртгэлийн үйлчилгээнд банкны цахим төлбөрийн системийг нэвтрүүлэх;

3.8.5.Төрийн бусад байгууллагуудын мэдээллийн сантай холбогдож, бүртгэлийн үнэн зөв, шуурхай байдлыг хангах;

### **3.9.Хөтөлбөрийн 9 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.9.1.Бүртгэлийн байгууллагын нээлттэй болон хязгаарлагдмал хүрээнд ашиглаж болох мэдээллийг нээлттэй ашиглуулах боломжийг бүрдүүлэх;

3.9.2.Монгол Улсын Засгийн цаазын 2017 оны 159 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж, бүртгэлийн байгууллагын тогтмол үйлчилгээнүүдээ “Үндэсний дата” төвд програмчилж, гарган өгөх;

3.9.3.Бүртгэлийн байгууллага бусад төрийн байгууллагаас шаардагдах мэдээллээ “Үндэсний дата” төвөөр дамжуулан авч, үйлчилгээндээ ашиглах;

3.9.4.Цахим нотариат системийг бүртгэлийн үйл ажиллагаанд бүрэн ашиглан, хэрэглээг нэмэгдүүлэх.

### **Дөрөв.Хөтөлбөрийн хүрэх үр дүн**

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1.Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр бүртгэлийн байгууллагын системийн хэмжээнд ашиглагдаж байгаа техник ба програм хангамж, мэдээллийн сан шинэчлэгдэж боловсронгуй болсон байна.

4.1.2.Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр архивын эх нотлох баримтыг цахимжуулахад шаардагдах програм хангамж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдаж, архивын эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, архивын зориулалтын байртай болон архивын хадгалалт хамгаалалт, үндэсний аюулгүй байдлын зорилт хангагдаж, анхан шатны нэгжээс үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх боломж бүрдэнэ.

4.1.3.Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний баримт бичиг үйлдвэрлэх хэвлэх үйлдвэрийг өргөтгөснөөр үндэсний энгийн цахим гадаад паспортад бичилт хийх хүчин чадалтай улсын тусгай үйлдвэр байгуулагдаж, төрөөс олгож буй баримт бичгийн болон иргэний мэдээллийн нууцлал, аюулгүй байдал хангагдана.

4.1.4.Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр олон улсын технологийн чиг хандлагад нийцүүлэн бүртгэлийн мэдээллийн сан, програм хангамжид мэдээллийн сангийн удирдлагын шинэ технологи нэвтрүүлж, сайжруулснаар бүртгэлийн мэдээллийн сан нэгдсэн удирдлагатай болж, суурь цахим мэдээллийн сангийн үнэн зөв, найдвартай байдал бий болсон байна.

4.1.5.Хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санд иргэн, хуулийн

этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хаягийн сан холбогдож, улсын хэмжээнд хаягийн нэгдсэн стандартад шилжсэн байна.

4.1.6.Хөтөлбөрийн 6 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр бүртгэлийн байгууллагын хүний нөөцийн мэдлэг, ур чадвар дээшилж, бүртгэлийн үйл ажиллагаа сайжирсан байна.

4.1.7.Хөтөлбөрийн 7 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн бичил санах ойд суурилуулсанаар цахим орчинд иргэнийг таних нөхцөл бүрдэж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэнэ.

4.1.8.Хөтөлбөрийн 8 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний цахим системд бүртгэлийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлж бусад шаардлагатай мэдээллийн сангуудтай улсын бүртгэлийн мэдээллийн санг холбоно.

4.1.9.Хөтөлбөрийн 9 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр “төрийн цахим мэдээлэл солилцох систем”-ээр дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд суурилсан иргэн, хуулийн этгээдийн үнэн зөв мэдээллийг солилцож, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ.

### **Тав.Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт**

5.1.Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

5.1.1. Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирна.

5.1.2. Үйлчилгээ үзүүлэх, авахад зарцуулах хугацаа багасна.

5.1.3. Иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.

5.1.4. Төрийн байгууллагууд хоорондын мэдээллийн сангийн уялдаа холбоо сайжирна.

5.1.5. Мэдээллийн сангийн аюулгүй байдал хангагдана.

5.1.6. Иргэд чирэгдэлгүйгээр, шуурхай цахим үйлчилгээ авна.

5.1.7. Бүртгэлийн үйлчилгээг хүн бүр тэгш хүртэх нөхцөл бүрдэнэ.

5.1.8. Хүний эрх хангагдаж “Иргэн төвтэй нийгэм”-ийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулна.

5.2.Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

5.2.1. Төрөөс үйлчилгээ авах иргэдийн болон төрийн зардал буурна.

### **5.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт /он/	Зорилтот түвшин /2021 он/
<b>Зорилт 1</b> Бүртгэлийн байгууллагын системийн хэмжээнд ашиглагдаж байгаа	Иргэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн програм хангамжийг шинэчлэн сайжруулсан байна.	2017	2018 он 100%
	Хуулийн этгээдийн		

техник ба програм хангамж, мэдээллийн санг сайжруулах;	бүртгэлийн, архивын нэгдсэн програм хангамж боловсруулсан байна.	2017	2019 он 100%
	Бүх мэдээллийн сангуудыг хянадаг програм хангамжтай болно.	2017	2019он 100%
	Бүртгэлийн системд ашиглагдаж байгаа сервер, компьютер, тоног төхөөрөмжийн 80-аас доошгүй хувийг шинэчилнэ.	2017	2020 он 100%
	Нийслэлийн 67 хороо, хүн ам ихээр төвлөрсөн 50 сумыг шат дараалалтайгаар улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбоно.	2017 онд 84 хороо 5 сум холбогдсон байгаа	2018 онд 67 хороо 100% 2021 50 сум 100%
<b>Зорилт 2</b> Архивын эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, боловсронгуй болгох	Архивын байранд тавигдах шаардлагад нийцсэн зориулалтын байрны зураг төслийг гаргаж, бариулна.	2017	2020 он 100%
	Архивын эх нотлох баримтыг цахимжуулахад шаардагдах програм хангамж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.	2017	2019 он 100%
	Иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын эх нотлох баримтыг 100 % цахимжуулна.	2017	2020 он 100% цахимжин үйлчилгээнд ашиглана.
<b>Зорилт 3</b> Дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний баримт бичиг үйлдвэрлэх хэвлэх үйлдвэрийг өргөтгөх;	Монгол Улсын иргэний үнэмлэхийн нууцлал бүхий бэлдэц, бичилтийг хийх, үндэсний энгийн цахим гадаад паспорт бичилт хийх хүчин чадалтай улсын тусгай үйлдвэрийг байгуулна.	2017	2019 он 100%
	Иргэний иргэний үнэмлэхийн бэлдэцийг бэлтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авна.	2017	2019 100%
	Олон улсын стандартын шаардлагад нийцсэн үндэсний энгийн цахим гадаад паспорт хэвлэх	2017	2019 он Иргэдэд цахим гадаад паспорт

	машиныг хэрэглээнд нэвтрүүлнэ.		олгосон байна
<b>Зорилт 4</b> Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгө, оюуны өмчийн мэдээллийн санг чанаржуулах, нэгдсэн удирдлага бүхий систем бий болгох	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх, улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн чанарыг сайжруулна.	2017	2019 он 100% хангагдсан байна.
	Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтээр гаргаж байгаа эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг өрхийн нийгэм, эдийн засагтай холбох, хүн амын ердийн хөдөлгөөний талаарх тоон мэдээг улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргах, олон улсын жишигт нийцсэн статистик шинээр бий болно.	2017	2018 он 50% 2019 он 100%
<b>Зорилт 5</b> Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгох	Газар зүйн мэдээллийн санд суурилсан хаягийн нэгдсэн санд үндэслэн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн шинэчилсэн хаягийг бүртгэнэ.	2017	2018 он 50% 2019 он 100%
	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн систем дэх газрын нэгж талбарын дугаарыг газрын кадастрын суурь мэдээллийн сантай холбож, уялдуулна.	2017	2018 он 50% 2019 он 100%
	Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгох	2017	2018 он 20% 2019 он 50% 2020 он 100%
<b>Зорилт 6</b> Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, шинэ дэвшилтэт технологийн шаардлагад нийцүүлэн хүний нөөцийг	Мэдээллийн технологийн чиглэлийн 5 аас доошгүй албан хаагчдыг шинэ дэвшилтэт технологийн шаардлагад нийцүүлэн гадаад улсад мэдлэг, ур чадварыг сайжруулан, давтан сургаж, чадавхжуулсан байна.	2017	2018 онд 40% 2019 онд 100%
	Бүртгэлийн төв, орон		

чадавхжуулах	нутгийн нэгжийн албан хаагчдыг мэргэшсэн, ур чадвар бүхий боловсон хүчнээр хангасан байна.	2017	2020он 100%
<b>Зорилт 7</b> Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, иргэний үнэмлэхийн бичил санах ойд цахим өгөгдлийг суурилуулах	Шинээр хэвлэгдэх иргэний үнэмлэхийн бичил санах ойд тоон гарын үсгийн түлхүүрийн хослолыг үүсгэх, чипийн файлын бүтэц, карт хэвлэх системийн болон PKI идэвхжүүлэх програм хангамжийг боловсруулсан байна.	2017	2018он 100%
	Иргэдэд олгогдсон иргэний үнэмлэхийн PKI апплетыг шинэчилж, 2048 бит түлхүүрийн хослолыг бичих боломжтойгоор програм хангамжийг боловсруулсан байна.	2017	2018он 100%
	Иргэний үнэмлэхийн бичил санах ойд тусгагдсан тоон гарын үсгийн мэдээллийг таних програм боловсруулсан байна.	2017	2018он 100%
	Бүртгэлийн анхан шатны нэгжээр дамжуулан иргэдэд тоон гарын үсгийг олгох ажлыг эхлүүлж, хэрэглээнд нэвтэрсэн байна.	2017	2020он 100%
<b>Зорилт 8</b> Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт оруулж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцлийг бүрдүүлэх	Төрийн үйлчилгээний цахим системд бүртгэлийн 60 үйлчилгээг холбож, цахим хэлбэрт шилжсэн байна.	2017	2021он 100%
	Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжсэн, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна.	2017	2020он 100%
<b>Зорилт 9</b> Төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох	“Төрийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж, бүртгэлийн байгууллагын тогтмол үйлчилгээнүүдээ “Үндэсний дата” төвд програмчилж, гарган өгөх;	2017	2018он 100%
	Цахим нотариат системийг		

	иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаандаа ашигласан байна.	2017	2020 он 100%
--	--	------	-----------------

### **Зургаа.Хөтөлбөрийн санхүүжилт**

6.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1.Улс, орон нутгийн төсөв, гадаад зээл тусламж;

6.1.2.Олон улсын байгууллага, гадаадын улс орны төсөл, зээл, тусламж;

6.1.3.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив;

6.1.4.Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

6.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд **92.9** тэрбум төгрөг шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоололтой байна.

### **Долоо.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

7.1.Хууль зүй, дотоод хэргийн яам болон бүртгэлийн байгууллага нь “Нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж, зохион байгуулалт, арга зүйн зөвлөмжөөр хангана.

7.2.Хууль зүй, дотоод хэргийн яам болон бүртгэлийн байгууллага нь “Нэг иргэн, нэг бүртгэл хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, үр дүнд тогтмол хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана.

7.3.“Нэг иргэн, нэг бүртгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж буй ажлын явцын талаар тухай бүр олон нийтэд мэдээлэл хийх ажлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд хариуцна.

### **Найм.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө**

8.1.Хууль зүй, дотоод хэргийн яам нь жил бүр үндэсний хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

8.2. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд жил бүр танилцуулна.

8.3 Хууль зүй, дотоод хэргийн яам хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүр Засгийн газарт танилцуулна.

8.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.5.Хөтөлбөрийн явцын болон үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болно.

--- оОо ---